

НИЙГМИЙН АЖИЛ-НИЙГМИЙН ХАЛАМЖ, ХАМГААЛАЛ

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙГ ГЭРЭЭЛЭН ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Б. Бат-Өлзий

Нийгмийн ажлын доктор (Ph. D.)

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль. Бизнесийн удирдлага,
хүмүүнлэгийн сургууль*

bbatulzii04@gmail.com

***Хураангуй:** Энэхүү өгүүллээрээ Монгол Улсын нийгмийн хамгааллын салбарын төрийн байгууллагын чиг үүргийг гэрээлэн гүйцэтгүүлэх үйл ажиллагаанд баримтын анализ хийх зорилго дэвшүүлсэн. Хамрах хүрээний хувьд ХНХЯ болон түүний харъяа агентлагуудын бүтэц, чиг үүрэгт анализ хийж, тэдгээрийн зарим чиг үүрэг, үйлчилгээг засгийн газрын бус байгууллагууд буюу хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудаар гэрээлэн гүйцэтгүүлэх боломжтой гэсэн дүгнэлт хийсэн.*

***Түлхүүр үгс:** Төрийн байгууллага, засгийн газрын бус байгууллага, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, чиг үүрэг, гэрээлэн гүйцэтгэх, нийгмийн хамгаалал, агентлаг*

УДИРТГАЛ

Өгүүллийн хүрээнд дэвшүүлж буй асуудал нь нийгмийн шилжилтээ бүрэн хийж дуусаагүй манай орны хувьд чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Бүхнийг төр өөртөө төвлөрүүлж хэрэгжүүлдэг байсан (1990 оноос өмнө) манай орон өмчийн олон хэлбэрийн байгууллагууд зэрэгцэн бие биенээ дэмжин тэтгэж байдаг ардчилсан нийгмийн тогтолцоонд бүрэн шилжиж амжаагүй гэж судлаачийн хувьд үзэж байна. Ялангуяа манай төрийн бүтэц данхар том, зардал өртөг өндөртэй, өөртөө олон асуудал буюу чиг үүргийг төвлөрүүлсэн хэвээр байна. Өндөр хөгжилтэй орнуудад төрийн байгууллагын шаталсан тогтолцоон дахь захиргааны байгууллагууд нь түвшин бүрдээ тохирсон, өөр хоорондоо уялдаа бүхий нийгмийн хөгжлийг хангах бодлого боловсруулж, тухайн бодлогоо үр дүнтэй хэрэгжүүлэх зохицуулалтын механизм хэрэгжүүлдэг, харин гүйцэтгэх үйл ажиллагаандаа хувийн хэвшил, төрийн бус байгууллага, их дээд сургууль зэрэг өмчийн бусад хэлбэрийн мэргэжлийн байгууллагуудыг гэрээний

үндсэн татан оролцуулж, татвараас бүрдсэн төрийн хөрөнгө мөнгийг үр ашигтай зарцуулах арга хэлбэрийг түлхүү сонгож байна. Тиймээс энэ асуудлыг Монгол Улсын нийгмийн хамгааллын салбарын жишээн дээр авч үзэж, нөхцөл байдал ямар байгааг тодорхойлох шинжилгээ хийлээ.

ОНОЛ, АРГА ЗҮЙ

Төр болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хоорондын харилцааны тухай асуудал судлаачдын анхааралд ихээхэн өртөж байна. Нийгмийн асуудлыг зөвхөн төр дангаараа шийдэж чадахгүй гэсэн үзэл бодол түгээмэл болсон. Тухайлбал судлаач Жеймс, Маккарти, Саламон, Анхайер нар төрийн гүйцэтгэх чиг үүрэгт хувийн хэвшил болон төрийн бус байгууллагууд чухал дэмжлэг болно гэдгийг онцолдог. (1) 1980-аад оны эхээр Европын улсуудын төрийн захиргааны салбарт хийгдсэн шинэчлэлийн хүрээнд төрийн байгууллагын чиг үүргийг хувийн хэвшил, ТББ ба иргэний нийгмийн үйлчилгээний байгууллагуудаар гэрээлэн гүйцэтгүүлэх (contracting out) хандлага бий болсон байдаг. Гэрээлэн гүйцэтгэх гэсэн энэ нэр томъёог Германы эрх зүйд “beleihung” буюу “зээлдүүлэх” гэсэн ойлголтоор илэрхийлэж аж. Энэ нь тухайн чиг үүргийг бүрмөсөн шилжүүлэх ажиллагааг илэрхийлдэггүй, харин хувийн хэвшлийн субъектүүд өөрийн нэрээр төрийн захиргааны чиг үүргийг тогтмол бие даан хэрэгжүүлэх эрхийг гэрээлэн авсан байдаг байна. Өндөр хөгжилтэй болон хөгжиж буй олон оронд нийгмийн халамж хамгаалын үйлчилгээг төрөөс хариуцдаг тогтолцоо, стратегийг хэрэгжүүлж байна. Англо-Саксоны гэж нэрлэгддэг орнууд болох Авсрали, Канад, Шинэ Зеланд, Их Британи, АНУ (2) болон бусад орнуудад нийгмийн салбарын хувьчлал ба гэрээлэн гүйцэтгүүлэх үйл ажиллагаа амжилттай хэрэгжиж байна. Нийгмийн халамжийн үйлчилгээг төр хариуцдаг нийгмийн баримжаа бүхий уламжлалт тогтолцоотой Франц, Швед улсуудад ч нийгмийн салбарын үйлчилгээнд хувийн салбарыг дэмжих хандлага бий болоод байна (3). Европын холбооны гишүүн орнуудад нийгмийн салбарын хувьчлал нийтлэг үзэгдэл болж “улсын болон хувийн хэвшлийн нийгмийн халамжийн холимог тогтолцоо”, “холимог эдийн засгийн халамж” (4) гэдэг ойлголтын талаар ярих болсон. Түүнчлэн Болгар, Чех, Унгар, Польш, Румын, Словак зэрэг хөгжиж буй орнууд нийгмийн салбарын хувьчлалыг ихээхэн сонирхож байна (5). Нийгмийн халамжийн чанарыг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах, үйлчилгээг зохих хэмжээнд авч чадахгүй байгаа хүн амд үйлчилгээ хүргэх, үйлчилгээ үзүүлэх янз бүрийн стратегийг туршин хэрэгжүүлэх зэрэг олон шалтгааны улмаас Засгийн газрууд нийгмийн салбарын үйлчилгээг гэрээлэн хэрэгжүүлдэг (6) байна.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Судалгааны мэдээллийг баримт бичиг судлах аргаар цуглуулж, шинжилгээ хийв. Монголын нийгмийн хамгааллын салбарын төрийн байгууллагын чиг үүргийг гэрээлэн гүйцэтгүүлэх үйл ажиллагааны өнөөгийн байдлыг шинжлэхдээ хайгуул судалгааны түвшинд олдсон харьцангуй цөөн тооны баримт бичигт тулгуурласан гэдгээ тэмдэглэж байна. Тиймээс цаашдаа сэдвийн хүрээнд илүү ул суурьтай, нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай. Энэ өгүүллийн түвшинд хийгдсэн судалгааны үр дүн нь нийгмийн хамгааллын салбарын шийдвэр гаргах түвшинд асуудлыг хөндөж, судлаачид болон сонирхогч талуудын анхаарлыг хандуулах үндэс болно гэж үзэж байна.

Баримт бичгийн шинжилгээндээ хууль, дүрэм журам, бодлогын баримт бичгүүд болон Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагуудтай холбоотой баримт мэдээллүүдийг түлхүү ашигласан болно. Мөн нийгмийн хамгааллын салбартай холбоотой бусад мэдээллүүдийг ч боломжит хэмжээгээр судлагдахуун болгосон.

1. Эрх зүй, бодлогын орчинд хийсэн шинжилгээ:

Анх 1993 онд Монгол Улсын Засгийн газрын тухай хууль батлагдсан байх ба уг хуулийн 19-р зүйлд *“Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно. Төрийн гүйцэтгэх байгууллагын чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж, тэр тухайдаа улсын төсвөөс санхүүжиж байгаа байгууллага нь Засгийн газрын шийдвэрийг биелүүлж, уг ажлаа Монгол Улсын зохих сайдын өмнө хариуцна”* (7) гэж заасан байна. Хуулийн энэ заалт нь Монгол Улсад анх удаа төрийн байгууллагын чиг үүргийг гэрээлэн гүйцэтгүүлэх үзэл санаа, бодлогын эхлэл, суурь нь болсон ба өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байна. Засгийн газрын бус байгууллага гэдэгт төрийн бус байгууллага, компани гэх мэт ашгийн төлөө болон ашгийн төлөө бус, төрийн байгууллагад хамаардаггүй хуулийн этгээдийг ойлгодог байна. (8)

Засгийн газрын тухай хуулийн 19-р зүйлийн хэрэгжилтийг хангахын тулд Засгийн газраас 1995 онд 111 дүгээр тогтоолоор *“Төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлэх журмыг”*-ыг батлан гаргажээ. Уг журмын нийтлэг үндэслэлд *“Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн зохицуулалт, мэдээлэл, шинжлэл судлалын зэрэг төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг*

Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлэх, үүнтэй холбогдон гарах зардлыг санхүүжүүлэхэд энэ журмыг баримтална. Төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг Засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай шийдвэрийг холбогдох сайдын санал болгосноор Засгийн газар гаргана. Засгийн газрын бус байгууллага нь төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг гүйцэтгэхдээ хууль тогтоомж, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээг баримталж, холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Засгийн газрын бус байгууллагаас төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг эрхлэн гүйцэтгэхтэй холбогдон гарах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ” (9) гэж заасан байна.

Мөн 2009 онд УИХ-ын 64 дүгээр тогтоолоор “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого” гэсэн баримт бичгийг баталсан. Уг бодлогын баримт бичгийн 5.2-т “Түншлэлд хувийн хэвшлийг төлөөлж компани; нөхөрлөл, хоршоо; төрийн бус байгууллага; хувь хүн оролцоно” (4) гэж заажээ. Харин уг баримт бичгийн дөрөвдүгээр зүйлд бодлогыг хэрэгжүүлэх арга зам, хэлбэрийг тодорхойлсон байна. Тухайлбал, түншлэл нь дараах төрөлтэй байна. Үүнд:

1. Нийгмийн салбарын түншлэл (эрүүл мэнд; боловсрол; соёл урлаг; шинжлэх ухаан; бусад);

2. Дэд бүтцийн салбарын түншлэл (эрчим хүч, сэргээгдэх эрчим хүч; дулаан дамжуулах болон түгээх сүлжээ; мэдээлэл, харилцаа холбоо; усан хангамж, ариутгах татуурга; нийтийн тээвэр; авто зам; орон сууц; бусад);

3. Төрийн тодорхой чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх түншлэл;

4. Үндэсний болон бүс нутгийн хэмжээний томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх түншлэл;

5. Байгаль орчны салбарын түншлэл (экологи; хог хаягдлын удирдлага) (10).

Түүнчлэн 2008 онд Засгийн газраас хоёр тогтоол гарсан байна. Эхнийх нь 2008 онд Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах тухай 93-р тогтоол. Энэ тогтоолд “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон төсвийн гүйцэтгэлд мониторинг хийх үйл ажиллагаанд төрийн бус байгууллагуудыг оролцуулах нөхцөл бүрдүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосон” байна. (11) Мөн 2010 онд 325 дугаар тогтоолоор төрийн бус байгууллагад гэрээний үндсэн дээр хариуцуулан гүйцэтгүүлэх зөвшөөрлийн жагсаалтыг баталсан ба зөвшөөрөл олгох үйл ажиллагааг

гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж, яам, Засгийн газрын агентлагийн хариуцах зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх чиглэл баримтлан ажиллахыг тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүдэд даалгасан байна. (12)

Өгүүллийн хүрээнд цуглуулсан баримтаас харвал төрийн байгууллагын чиг үүргийг гэрээлэн гүйцэтгүүлэх харилцаа нийгмийн хамгааллын салбарын хуулиудад нэлээд тодорхой, сайн гэж үнэлэхүйц хэмжээнд тусгагдсан байна. Үүнд Нийгмийн халамжийн тухай хууль (13), Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (14), Хүүхэд хамгааллын тухай хууль (15), Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль (16), Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль (17), Ахмад настны тухай хуулиудыг (18) нэрлэж болно. Эдгээр хуулиудад нийгмийн хамгааллын салбарын төрийн байгууллагын чиг үүрэг, түүн дотроо хүн амын зорилтот бүлгүүдэд үзүүлэх үйлчилгээнүүдийг хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагуудаар гэрээгээр гүйцэтгүүлэх талаар нэлээд тодорхой тусгаж өгсөн байна. Дээрх олон хуулийн зүйл, заалт тус бүрийг энд өгүүлэх нь хэт нуршсан хэрэг болох учраас зарим хууль дээр жишээлэн авч үзлээ. Тухайлбал Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10-р зүйлд *“Эрсдэлт нөхцөлд байгаа, гэмт хэргийн хохирогч болсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, ял шийтгүүлж, албадлагын арга хэмжээ авагдсан, сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь тусалж, дэмжих чиглэлээр дараах хариу үйлчилгээ үзүүлнэ. Үүнд мэдээлэл авах, илрүүлэх, шалгах; нөхцөл байдлын үнэлгээ хийх; аюулгүй байдлыг хангах; дэмжих, холбон зуучлах; хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ үзүүлэх; гэр бүлд нь эргэн нэгтгэх; гэж заагаад Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг төрийн байгууллага, эсхүл тухайн чиглэлээр мэргэшсэн иргэн, магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээдээр төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх замаар үзүүлнэ”* (15) гэж хуульчилсан байна. Түүнчлэн уг хуулийн Хүүхэд хамгааллын хамтын ажиллагаа гэсэн 4-р бүлгийн 18-р зүйлд *“Хүүхэд хамгаалалд бүх шатны төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэн, гэр бүл, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг дэмжих”* гэж заагаад 5-р бүлгийн 21.4-т *“Олон улсын төрөлжсөн байгууллага, магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллага, хуулийн этгээдээр хүүхдийн эрхийн болон хүүхэд хамгааллын талаар хөндлөнгийн хяналт, шинжилгээ хийлгэж болно”* 23.1-т *“Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийг улсын төсөвт тусгаж санхүүжүүлнэ”* (15) гэж тус тус хуульчилсан байна.

Нийгмийн хамгааллын салбарт төрийн байгууллагын чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэх асуудал Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулинд маш тодорхой нарийн тусгагдсан байна. Уг хуулийн 22-р зүйлд

Төрийн бус байгууллагын чиг үүргийг тусгайлан хуульчилсан байна. Үүнд: *“Төрийн бус байгууллага нь дүрмийнхээ зорилгод нийцүүлэн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэж болно. Үүнд: хохирогчид аюулгүй хамгаалалт, эмнэлэгийн тусламж үйлчилгээ, сэтгэл зүйн үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ, эрх зүйн туслалцаа, холбон зуучлах үйлчилгээ, олон нийтэд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл түгээх, сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах, хохирогчийг түр хамгаалах байраар хангах зэрэг үйлчилгээг энэ чиглэлийн магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллага гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ, гэрээний үндсэн дээр үйлчилгээ үзүүлж байгаа төрийн бус байгууллагад олгох санхүүжилт, ажилтны цалин, урамшуулал нь адил төрлийн үйлчилгээ үзүүлж байгаа төрийн байгууллагынхаас багагүй байна”* (14) хэмээн заасан байна.

Дээрх салбарын хуулиудаас гадна УИХ-аар 2005 онд батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хууль (19) гэж байдаг. Уг хуулийн зорилтыг *“төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, уг ажиллагаанд хяналт тавих, гомдол гаргаж шийдвэрлүүлэх, энэхүү хуулийг зөрчигчдөд хариуцлага хүлээлгэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино”* (19) гэж заасан нь уг хуулийн үйлчлэл нэлээд өргөн цар хүрээтэйг харуулж байна. Өөрөөр хэлбэл энэ хуулийн үйлчлэлд төрийн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагаанаас гадна төрөл бүрийн бараа материал, ажил, үйлчилгээг худалдан авах, зохион байгуулах, сонгон шалгаруулах, гомдол маргааныг шийдвэрлэх гэх мэт асуудлуудыг тусган хуульчилжээ. Уг хуулийн нэг онцлог нь ажлын даалгавар, захиалгад үндэслэн төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр нэг удаагийн болон богино хугацааны худалдан авах үйл ажиллагааны харилцааг түлхүү зохицуулсан хууль юм.

Дээрх бодлогын болон эрх зүйн баримт бичгүүдээс харвал төрийн зарим чиг үүргийг, тэр дундаа нийгмийн хамгааллын салбарын тодорхой хуулиудаар төрийн бус байгууллага болон хувийн хэвшил, бусад хуулийн этгээдүүдээр гэрээлэн гүйцэтгүүлэхийн зөвшөөрсөн эрх зүйн хэм хэмжээнүүд байна. Гэхдээ дээрх хуулиудын зүйл заалтуудыг нарийвчлан шинжилж үзвэл “гэрээлэн гүйцэтгэж болно, хэрвээ гэрээлэн гүйцэтгүүлэх юм бол санхүүжилтийг нь төрөөс олгоно” гэсэн агуулга харагдаж байна. Энэ нь нөгөө талаар заавал гэрээлэн гүйцэтгүүлэх албагүйг ч бас давхар агуулж байна. Нөгөө талаар дээрх хуулиудад нийгмийн хамгааллын салбарт төрийн бус байгууллага, хувийн хэвшил болон бусад хуулийн

этгээдээр гэрээлэн гүйцэтгүүлэх чиг үүрэг, үйлчилгээнүүдийг нарийвчлан тодорхой заагаагүй, бүрхэгдүүлсэн дутагдалууд ажиглагдсан.

2. Хэрэгжилтийн байдалд хийсэн шинжилгээ

Хэрэгжилтийн байдлыг шинжлэхэд тулгарсан асуудал бол мэдээллийн нээлттэй бус байдал байв. ХНХЯ болон түүний харъяа агентлагуудын холбогдох алба хэлтсийн дарга, мэргэжилтэнгүүд мэдээлэл өгөхөөс татгалзах, ямар нэгэн шалтгаан тайлбар хэлэх, газар албадын мэргэжилтэнгүүд өөрсдөөсөө зайлуулж бие биерүүгээ асуудлыг түлхэх зэрэг хүндрэлтэй асуудал гарсан. Мөн дээрх байгууллагуудын албан ёсны цахим хуудас бүрэн бус, шинжилгээний шаардлага хангахгүй, хуучирсан, бүрхэг мэдээлэлтэй байсан ба аль ч байгууллага /ХНХЯ, ХХҮЕГ, ГХЗХГ/ жил, улирлын үйл ажиллагааны тайлангаа вэб хуудсандаа байршуулдаггүй байна.

Дээрх нөхцөл байдал нь 2011 онд батлагдсан Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна. Уг хуулийн 6-р зүйлд Мэдээллийн ил тод байдал дараах төрөлтэй байна гэжээ. Үүнд: *“үйл ажиллагааны ил тод байдал; хүний нөөцийн ил тод байдал; төсөв, санхүүгийн ил тод байдал; төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал”* гэж заасан байх ба энэхүү өгүүллийн судлагдахууны хүрээнд хүссэн мэдээллүүдийг дээрх төрийн байгууллагууд өгөхөөс татгалзах үндэслэл байхгүй байна. Харамсалтай нь тодорхойгүй шалтгааны улмаас мэдээлэл өгөөгүй учраас олон нийтийн мэдээллийн хэрэгслийн мэдээлэл, албаны хүний ярилцлага болон нийтэд зориулагдсан ном, товхимол зэргээс цөөн тооны баримтууд цуглуулж шинжилгээ хийлээ.

Юуны өмнө Монгол Улсын нийгмийн хамгааллын салбарын төрийн байгууллагуудын бүтцийн схемийг шинжилж үзэв. Өөрөөр хэлбэл ХНХЯ, түүний агентлагуудын бүтэц дотор чиг үүргээ гэрээлэн гүйцэтгүүлэх боломжтой ямар нэгжүүд байна вэ гэдгийг судалсан. Судлаад үзэхэд чиг үүргээ гэрээлэн гүйцэтгүүлэх бүрэн боломжтой нэгж /байгууллага, алба, хэлтэс/-үүд цөөнгүй байна. Өөрөөр хэлбэл эдгээр нэгжүүд яам, агентлагийн бүтцэд байх онцын шаардлагагүй, тэдгээрийн чиг үүргийг хувийн хэвшил, төрийн бус байгууллага болон их дээд сургууль гэх мэт засгийн газрын бус байгууллагуудаар гэрээлэн гүйцэтгүүлэх бүрэн боломжтой гэж үзэж байна. Үүнд:

1. ХНХЯ-ны харъяанд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт нь Монгол улсын Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн "Төсвийн зарим байгууллагыг өөрчлөн зохион байгуулах, татан буулгах тухай" 55 дугаар тогтоолоор байгуулагдсан байна. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн хамгаалал болон хүн амын

хөгжлийн бодлогын суурь судалгаа, шинжилгээ, хэтийн болон ойрын төлөвлөлт, тооцоолол хийж, зөвлөмж боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлдэг төрийн байгууллага юм байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт нь захирал, дэд захирлаасаа эхлээд үйлчлэгч, жолооч хүртэл нийт 34 ажилтан албан хаагчидтай ба доорх чиг үүрэг бүхий үндсэн 5 нэгжээс бүрддэг байна. Үүнд:

- **Захиргаа, тамгын газар:** Захирал, дэд захирлаас гадна 16 хүнтэй. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн өдөр тутмын үйл ажиллагааг хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн дагуу хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлж, удирдан зохион байгуулах.
- **Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын судалгааны сектор:** 1 эрхлэгч, 5 ЭШ-ний ажилтан, нийт 6 хүнтэй. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны асуудлаар болон хөдөлмөрийн зах зээлийн барометрийн судалгаа хийх, дунд, урт хугацааны таамаглал, загварчлалыг хөгжүүлэх шинжилгээ хийж, бодлогын зөвлөмж боловсруулах.
- **Хүн амын хөгжлийн бодлогын судалгааны сектор:** 1 эрхлэгч, 4-н ЭШ-ний ажилтан, нийт 5 хүнтэй. Хүн амын хөгжлийн бодлогын асуудлаар эрдэм шинжилгээний суурь судалгаа, шинжилгээ хийх, загварчлалыг хөгжүүлэх, дүгнэлт өгөх, зөвлөмж боловсруулах.
- **Нийгмийн хамгааллын бодлогын судалгааны сектор:** 1 эрхлэгч, 4-н ЭШ-ний ажилтан, нийт 5 хүнтэй. Нийгмийн даатгал, тэтгэврийн бодлого, сангийн удирдлага, нийгмийн хамгааллын бодлогын болон нийгмийн халамжийн зорилтот бүлгийн халамжийн үйлчилгээний арга аргачлалын асуудлаар эрдэм шинжилгээний суурь судалгаа, шинжилгээ хийх, дүгнэлт, зөвлөмж боловсруулах.
- **Мэдээллийн технологийн сектор:** 1 эрхлэгч, 2 программист, 1 техник хангамжийн инженер, нийт 4 хүнтэй. Мэдээллийн технологийн хөгжлийг ашиглан судалгаа, шинжилгээний арга аргачлал, үр дүн, мэдээ мэдээллийг олон нийтэд шуурхай хүргэхэд дэмжлэг үзүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиг үүргүүдийг хэрэгжүүлдэг. (20)

Эндээс харвал тус байгууллагын чиг үүргүүдийг бүхэлд нь их дээд, сургууль, шинжлэх ухааны болон хавсарга судалгаа, зөвлөх үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн компаниудаар гэрээлэн гүйцэтгүүлэх бүрэн боломжтой юм.

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 8 сарын 24-ний өдрийн 55-р тогтоолоор 2013 оноос хойш Хөдөлмөрийн эрүүл мэнд, судлалын төв нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байсныг “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн

төв” болгон үндсэн чиг үүргийн дагуу өөрчлөн зохион байгуулсан. Гэхдээ уг байгууллагын үүсэл хөгжлийн түүхийн он цаг нь 1967 оноос эхлэлтэй ажээ. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн бүтэц 4 газар, 6 хэлтэс, 1 эмнэлэг, 1 сувилалтай. Үүнд: 1. Захиргаа удирдлагын газар, 2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн газар, 3. Сургалт судалгаа, мэдээлэл хамтын ажиллагааны газар, 4. Мэргэжлийн өвчин судлалын газар, 5. Сувилал. Хэдэн хүний орон тоотой үйл ажиллагаа явуулдаг нь талаар мэдээлэл олдоогүй. Тус байгууллага өөрийн үйл ажиллагааныхаа үндсэн чиглэлийг *“Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагуудын ажлын байранд хөдөлмөрийн болон эрүүл ахуйн нөхцөлийг судлах, үнэлгээ өгөх, ажлын байрны аюултай хортой хүчин зүйлсийг багасгах, арилгах арга хэмжээний зөвлөгөө зөвлөмж өгөх, ажилчдад эрүүл, аюулгүй зан үйлийг төлөвшүүлэх, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг (МШӨ) эрт илрүүлэх, эмчлэх, урьдчилан сэргийлэх, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан (ХЧА) иргэдэд хөдөлмөр зохицуулалтын магадлал хийх, холбогдох байгууллага, мэргэжилтнүүдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үндсэн чиг үүрэг бүхий Хөдөлмөр, нийгмийн хамгаалах яамны харъяа төрийн үйлчилгээний байгууллага юм”* гэж томъёолсон байна. (21)

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн зарим чиг үүргийг мөн адил их дээд, сургууль, мэргэжлийн шинжлэх ухааны байгууллага, эмнэлэг, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн компаниудаар гэрээлэн гүйцэтгүүлэх боломж байна гэж үзэж байна.

3. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар. Тус агентлаг нь олон талт чиг үүрэгтэй, нийгмийн хамгааллын салбарт голлох байр суурь эзлэх том агентлаг юм. Тус агентлагын нь 1-рт Нийгмийн халамжийн үйлчилгээ, 2-рт Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, 3-рт Мэргэжлийн боловсрол сургалтын үйлчилгээ гэсэн үндсэн 3 том багц үйлчилгээг орон даяар харъяа газар, хэлтсүүдээрээ дамжуулан иргэдэд хүргэх үндсэн чиг үүрэгтэй юм.

Тус агентлагийн тухайд цөөнгүй тооны ажил үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллага болон бусад хуулийн этгээдтэй гэрээлэн гүйцэтгүүлдэг байна. Үүнд:

- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ
- Ахмадын амралт сувилалын үйлчилгээ
- Ахмад настан болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэний төрөлжсөн асрамжийн үйлчилгээ
- Мэргэжлийн сургалт зэрэг үйлчилгээнүүдийг гэрээлэн гүйцэтгүүлдэг байна.

Гэвч дээрх үйлчилгээнүүдийг гэрээлэн гүйцэтгүүлэх үйл ажиллагаанууд бүрэн төгс, хангалттай түвшинд байж чадахгүй байна. Үйлчилгээг хэрхэн гэрээлэн гүйцэтгүүлж байгааг зарим нэг жишээн авч үзье. Тухалбал Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ. Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 зүйлд *“Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ” гэж иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор өрх, иргэнд дэмжлэг туслалцаа, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хэлнэ*” гэж заасан байх ба зөвлөгөө өгөх, сэргээн засах, түр асрамжлах, өдрийн үйлчилгээ зэрэг нийт 9 төрлийн үйлчилгээг, ахмад настан, хүнд нөхцөлд байгаа хүүхэд, хорих ангиас суллагдсан иргэн гэх мэт 12 зорилтот бүлэгт хүргэхээр хуульчилсан байдаг. (13) Гэвч олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний цар хүрээ, хамрах хүний тоо, зарцуулах хөрөнгийн хэмжээ сүүлийн жилүүдэд эрс буурсан үзүүлэлтэй байна. 2011 онд энэ төрлийн үйлчилгээнд нийт 32289 хүнийг хамруулж, 7184,6 сая төгрөг зарцуулж байсан нь хамгийн өндөр үзүүлэлт ажээ. Харин энэ цаг үеэс дээрх үзүүлэлт буурсаар 2017 онд 4261 хүнд 651.2 сая төгрөг зарцуулжээ. Энэ нь олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэгч байгууллагуудын үйл ажиллагаа мөн хэмжээгээр хумигдаж байгааг илэрхийлж байна. Мөн ахмадын амралт, рашаан-сувилалын үйлчилгээг магадлан итгэмжлэгдсэн дотоодын амралт, рашаан сувилалтын байгууллагуудаар гэрээлэн гүйцэтгүүлдэг байна. 2018 онд 106 магадлан итгэмжлэгдсэн дотоодын амралт, рашаан сувилалтын байгууллагатай гэрээ хийж уг үйлчилгээг хүргэжээ. (22)

ХХҮЕГ-аас дээрх 4-н төрлийн үйлчилгээг алдаатай оноотой ч гэрээлэн гүйцэтгүүлж байгаа нь сайн хэрэг юм. Дээрхээс гадна тус агентлагт гэрээлэн гүйцэтгүүлэх боломжтой чиг үүрэг, үйлчилгээнүүд олон байна. Тэдгээрийн дурьдвал:

- Тус агентлагийн харъяанд байдаг “Ахмадын үндэсний төв”-ийн нийгмийн хувьчлалд оруулах шаардлагатай. Энэ хуучин нэрээр Батсүмбэр дэх Ахмадын улсын асрамжийн газар юм. Уг байгууллага өнөөгийн байдлаар 5 алба, 92 ажилтантайгаар улсын төсвөөс 100 хувь санхүүжин ажиллаж байна.
- Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаа. Энэ судалгаа өнөөгийн байдлаар 3 удаа улсын хэмжээнд хийгдээд байна. Уг судалгааны үндсэн дээр өрхийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэдэг ба уг сангийн мэдээлэлд үндэслэн нийт өрхүүдийг амьжиргааны түвшингээр нь эрэмбэлж нийгмийн халамжийн болон төрийн бусад үйлчилгээнд хэрэгцээнд тулгуурлан хамруулах зорилготой билээ. Хамгийн анхны судалгааг их дээд сургууль, судалгааны байгууллагуудаар гэрээлэн гүйцэтгүүлсэн бол сүүлийн 2 судалгааг

ХХҮЕГ өөрийн бүтцээрээ дамжуулан өөрсдөө хийсэн. Олон улсад ийм судалгааг гэрээлэн гүйцэтгүүлж буй сайн туршлага байдаг.

- Зорилтот өрхийн хөгжлийг хангах төсөл, хөтөлбөр. Энэхүү хөтөлбөрийг ЗГ-ын 2016 оны тогтоолоор баталсан. Хөтөлбөрт төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог хангах талаар тусгасан боловч гол үүрэг, чиглэл төрийн бүх шатны байгууллагууд дээр байгаа ба төрийн бус байгууллагуудын оролцоо хязгаарлагдмал, тодорхой бус тусгагдсан байна. (23)
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бүх төрлийн чиг үүрэг, үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэх бүрэн боломжтой. Үүнд ажил зуучлах, хөдөлмөрийн бирж, гадаадад ажиллах хүч илгээх, гадаадаас ажиллах хүч авах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрөл бүрийн төслүүдийн үйл ажиллагааны менежмент, зохицуулалтуудыг гэрээлэн гүйцэтгүүлэх шаардлагатай байна. Нэн ялангуяа энэ төрлийн чиг үүрэг, үйлчилгээний менежментийг улам бүр төрийн нуруун дээр тохих, төвлөрүүлэх бодлого шийдвэрүүд батлагдаж байгаад анхаарах шаардлагатай. Үүний нэг тод жишээ нь ХНХ сайдын 2017 оны А/26 тоот тушаалын хавсралтаар батлагдсан Хөдөлмөр эрхлэлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамж юм. (18) Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих маш олон хөтөлбөрүүд хэрэгжиж дууссан болон хэрэгжиж байна. Эндээс заримаас нь дурьдвал ХБИ-ний ажлын байрыг дэмжих хөтөлбөр, Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр, Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр гэх мэт олон хөтөлбөрүүдийг нэрлэж болох ба эдгээрийн удирдлага, зохион байгуулалт, хэрэгжүүлэлтийн бүх түвшинд төрийн байгууллагуудын оролцоо маш өндөр байна.

4. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар.

2004 онд батлагдсан Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд (24) *“агентлаг нь илүү бодлогын түвшинд ажиллах, төрийн захиргааны байгууллага юм”* гэсэн агуулгаар чиг үүргийг нь тодорхойлж өгсөн байдаг. Гэтэл тус агентлагийн бүтцэд бодлогыг анхан шатанд гүйцэтгэх чиг үүрэгтэй нэгжүүд олон байна. Мөн зарим чиг үүрэг нь давхацсан нэгж ч бас байна. Тиймээс тус агентлагийн бүтцэд байгаа дараах нэгжүүдийн чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэх боломжтой гэж үзэж байна. Үүнд:

- Агентлагийн үндсэн бүтэц дотор Сургалт, судалгаа мэдээллийн төв, Хяналт, шинжилгээ үнэлгээний газар гэсэн чиглэл зорилго нь төстэй

/2-лаа судалгаа хийдэг/ хоёр нэгж үйл ажиллагаа явуулж байна. Гэтэл ХНХЯ-ны харъяанд Хөдөлмөр нийгмийн хамгааллын судалгааны институт гээд салбарын хэмээний судалгааны асуудлыг хариуцах чиглэл бүхий бие даасан байгууллага хүртэл байгааг дээр дурьдсан билээ. Эндээс харвал уг Сургалт судалгаа мэдээллийн төвийн чиг үүрэг нь агентлаг доторх нэгжтэйгээ төдийгүй салбарын хэмжээнд бүхий л судалгааны ажлын зангидах зориулалттай институттэй давхцсан байна. Ер нь бол Хөдөлмөр нийгмийн хамгааллын судалгааны институт ч тэр, тус агентлагийн Сургалт, судалгаа мэдээллийн төв ч тэр аль аль нь өөрсдийн чиг үүргээ их дээд сургууль, шинжлэх ухааны байгууллага, судалгааны төвүүдээр гэрээлэн гүйцэтгүүлэх бүрэн боломжтой гэж үзэж судлаачийн хувьд үзэж байна. Төрийн байгууллага өөрийн үйл ажиллагаандаа шаардлагатай сургалт, судалгааг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагуудаар гэрээлэн гүйцэтгүүлвэл чанар, үр дүн болон санхүүгийн хувьд үр ашигтай байх болно.

- Дараагийнх нь 108 хүүхдийн тусламжийн утасны үйлчилгээний төв юм. Уг төв нь долоо хоногийн 24 цагт дөрвөн ээлжээр, 22 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байгаа ба зөвлөгч 16, нийгмийн ажилтан 4, ахлах сэтгэл зүйч 1, зохицуулагч 1 ажиллаж байна. 108 утасны дуудлага, ачаалал маш их байдаг ба уг төв байгуулагдсанаар маш олон хүүхдийн эсрэг хүчирхийлэл болон эрсдэлт нөхцөл байдлуудыг цаг алдалгүй шийдвэрлэж чадсан байдаг. Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвийн 2018 оны эхний хагас жилийн байдлаар нийт 84,819 дуудлага хүлээн авч утсаар анхан шатны нийгэм сэтгэл зүйн тусламж, үйлчилгээг үзүүлсэн. Үүнээс зорилтот 38,581 дуудлага, хүүхэд хамгааллын үйлчилгээ шаардлагатай 14035, хүүхдийн эрхийн зөрчлийн тухай 1099 дуудлага, зөвлөгөө хүссэн 3585 дуудлага, мэдээлэл хүссэн 16,616 дуудлага, чимээгүй 10,896 дуудлага, санал гомдол 133 дуудлага хүлээн авснаас 27 дуудлагыг хяналтад авч хариу үйлчилгээнд холбон зуучилсан. Нийтдээ хүүхдийн эрхийн зөрчил, хүүхэд хамгааллын 2569 тохиолдлыг аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, холбогдох мэргэжилтэн, хамтарсан багт холбон зуучилж ажилласны үр дүнд 936 кейс буюу нийт бүртгэгдсэн тохиолдлын 36,4 хувийг амжилттай шийдвэрлэж, нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлж ажилласан байна (25). Хэдийгээр ийнхүү амжилттай ажиллаж байгаа тоон үзүүлэлт байгаа ч гэсэн энэ үйлчилгээ чиг үүргийг мэргэжлийн нийгмийн үйлчилгээний төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлээд агентлагийн зүгээс хяналт, зохицуулалтаа сайтар хийгээд явах нь илүү үр дүнтэй шийдэл болно.
- Тус агентлагийн харъяанд байдаг бас нэг томоохон нэгж бол Олон улсын хүүхдийн найрамдал төв юм. 1978 онд байгуулагдсан, олон улсын

хүүхэд багачуудыг хүлээн авч амраадаг уг төв нь манай улсын нэрийн хуудас болж өнөөг хүртэл үйл ажиллагаагаа тасралтгүй явуулсаар ирсэн. “Найрамдал” цогцолбор нь 150 гаруй ажилтан албан хаагчидтай жилийн турш тасралтгүй үйл ажиллагаа явуулж 40.000 гаруй хүүхэд, эцэг эхчүүдийг хүлээн авч үйлчилдэг. (26) Гэвч энэ байгууллагад нийгмийн хувьчлал /менежментийн/ хийх цаг нэгэнт болжээ. Монголд өнөөдөр цөөнгүй хувийн хэвшлийн хүүхдийн зуслангууд үйл ажиллагаа явуулж байгаа ба тэдгээрийн үйл ажиллагаанд тус агентлаг хяналт тавьж ирсэн бэлэн туршлага байгаа билээ. Найрамдал төвийг үйл ажиллагааг гэрээлэн гүйцэтгүүлсэнээр төрийн нуруун дээрээс багаггүй хэмжээний ачаа хөнгөрч, уг төвийн үйл ажиллагаа, менежментэд шинэ арга технологи нэвтрэх бүрэн боломжтой гэж үзэж байна.

- ГБХЗХГ-ын шууд харъяанд “Өнөр бүл” төв үйл ажиллагаа явуулдаг. Мөн л 1974 оноос үйл ажиллагаа явуулж эхэлсэн, өнчин буюу зорилтот бүлгийн хүүхдүүдэд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага юм. Энэ байгууллагыг нийгмийн хувьчлалд оруулах, чиг үүргийг нь хувийн хэвшилд шилжүүлж, төр хяналтаа тавиад явах нь үр ашигтай гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл төр бодлого гаргаж, норм стандартаа тогтоож, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих үүрэг хүлээх ба үйлчилгээ, чиг үүргийг нь гэрээлэн гүйцэтгэх хэлбэр нь илүү үр дүнтэй гэж үзэж байна. Манай оронд сүүлийн жилүүдэд хүүхдийн асрамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн байгууллагууд олон болсон нь энэ чиглэлийн туршлага байгааг харуулж байна.
- Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх түр хамгаалах байр. Агентлагийн шууд харъяанд нийт 4-н хүүхдийн түр хамгаалах байр үйл ажиллагаа явуулж байгаа ба Улаанбаатар, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Мандал сум, Дорноговь аймгийн Замын-Үүд сумдад тус тус байрладаг. Эдгээрээс гадна аймгуудын Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн дэргэд 10 гаруй түр хамгаалах байр үйл ажиллагаа явуулдаг байна. Эдгээр түр хамгаалах байранд хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд 72 цагийн хугацаанд байрших хуультай ч амьдрал дээр хүүхдийн эрсдэлт нөхцөл байдал тийм амархан шийдэгдэх боломжгүй учраас удаан хугацаагаар амьдруулж, хоол, хувцаслах болон бусад олон хэрэгцээг нь хангах шаардлага гардаг байна. Хүүхдийн түр хамгаалах байранд маш болгоомжтой хандах ёстой ч түүний чиг үүргийг мэргэжлийн байгууллагуудад гэрээлэн гүйцэтгүүлэх замаар илүү үр дүнд хүрэх бололцоотой. Манай улсад Хүчирхийллийн эсрэг үндэсний төв болон бусад цөөнгүй тооны хувийн хэвшил, төрийн бус

байгууллагууд хүүхэд, эмэгтэйчүүдийн түр хамгаалах байрны үйлчилгээг үзүүлж ирсэн туршлага байдаг.

- Дээрх бүтцийн нэгжүүдээс гадна тус агентлаг болон түүний харъяанд байдаг аймаг, нийслэл, дүүргийн хэлтэсүүд маш олон үйлчилгээг өөрсдийн нуруун дээр үүрч байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиуд батлагдан гарсантай холбоотойгоор тэдгээр хуулиудын хэрэгжилтийг хангах хүрээнд олон төрлийн үйлчилгээ, чиг үүргийг хамтарсан багаар болон төрийн захиргааны байгууллагын мэргэжилтэнгүүд гүйцэтгэх шаардлагатай болсон байна. Тухайлбал 2017 оны сүүлийн хагас жилийн байдлаар хамтарсан багаар 1298 гэр бүлд үйлчилгээ үзүүлсэн бол 2018 оны эхний хагас жилийн байдлаар 1548 гэр бүлд гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эрт шатанд илрүүлэх, таслан зогсоох, хохирогчийг нөхөн сэргээхэд чиглэсэн 7 төрлийн үйлчилгээ үзүүлж ажиллаж байна. (27) Гэтэл дээрх тооны үйлчилгээ үзүүлсэн гээд байгаа хамтарсан баг, түүний гишүүд нь тус бүрдээ өөр өөр чиглэлийн эрхэлсэн ажилтай төрийн албан хаагч нар байдаг бөгөөд тэр бүр үр дүнтэй хамтран ажиллах бололцоо муутай гэж үзэж байна. Хамтарсан багт сум, хорооны засаг дарга, цагдаа, өрхийн эмч, сургуулийн нийгмийн ажилтан, хорооны нийгмийн ажилтнууд ордог.

ДҮГНЭЛТ

1990 оны дунд үеэс Монгол Улсад төрийн зарим чиг үүргийг засгийн газрын бус байгууллагуудаар гэрээлэн гүйцэтгүүлэх асуудал хөндөгдөж, Засгийн газрын тухай хуулиас эхлэн салбарын олон хуулиудад тусгалаа олж, тодорхой хэмжээнд эрх зүйн үндэс тавигдсан байна. Гэвч эдгээр хуулиуд нь салангид, нэгдсэн зохицуулалтгүй, засгийн газрын бус байгууллагуудаар гэрээлэн гүйцэтгүүлж болно, гүйцэтгүүлэхгүй байсан ч болно гэсэн ерөнхий агуулгаар томъёологдсон нь нийтлэг байна. Энэүү өгүүлэлд Нийгмийн хамгааллын салбарын голлох агентлагуудын ямар чиг үүргүүдийг өмчийн бусад хэлбэрийн байгууллагуудаар гэрээлэн гүйцэтгүүлж болох вэ гэдэг асуудлыг ерөнхий байдлаар дэвшүүлсэн болно.

Онолын хувьд төрийн чиг үүргийг гэрээлэн гүйцэтгүүлэхийн зорилго нь байгууллагуудын хооронд өрсөлдөөнийг бий болгож, дэмжих замаар хөгжүүлэх, чадвахижуулах, илүү нарийн мэргэшүүлэх, улмаар үйлчилгээг чанартай гүйцэтгэх үндэс болж өгдөг. Мөн уг өрсөлдөөн нь үйлчилгээний өртгийг бууруулах, хэмнэлт гаргах, үр ашигтай байдлыг дээшлүүлдэг. Түүнчлэн төрийн үйлчилгээний төвлөрлийг сааруулах, зардлыг багасгах, үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх, иргэний нийгэм болон хувийн хэвшлийн оролцоог хангах, мэргэжлийн

байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, ажлын байр бий болгох гэх олон давуу талыг бий болгодог. Тиймээс цаашид нийгмийн салбарын чиг үүрэг, үйлчилгээг гэрээлэн гүйцэтгүүлэх үр дүнтэй загвар, тогтолцоо, журам зэргийг буй болгоход анхаарах, энэ чиглэлийн судалгааг өргөжүүлэх шаардлагатай гэж дүгнэж байна.

НОМ ЗҮЙ

- [1] Төрийн бус байгууллагад төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр шилжүүлэхэ нь. Харьцуулсан судалгаа. Хууль зүйн үндэсний хүрээлэн. УБ 2013 он
- [2] Paul Reed & Valerie Howe, The Study of Voluntary Organizations in Ontario in the 1990s;
- [3] A Refort to Participating Agencies, one in series of the Nonprofit Sector Knowledge Base Report, 1999;
- [4] Johan Hjertqvist (1999) Swedish Health-Care Reform: From Public Monopolies to Market Services. Montreal Economic Institute.
- [5] Sheila Kamerman & Al Kahn (1998) Privatization, Contracting and reform of Child & Family social Services. Washington, DC: The Finance Project, p. 9.
- [6] Caroline Newman (2000). "Comparative Study of NGO/Government Partnerships." The International Journal of Not-for-Profit Law 2
- [7] Lawrence Martin (1999) Contracting for Service Delivery: Local Government Choices. Washington, DC: International City/County Management Association;
- [8] Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, УИХ, 1993 он.
- [9] Монгол улсын захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар, УДШ, Ханнс-Зайделийн сан. УБ 2009 он.
- [10] Засгийн газрын 1995 оны 111 дүгээр тогтоол, Төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлэх журам, УБ 1995 он.
- [11] УИХ-ын 64-р дүгээр тогтоол, "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого" УБ 2009 он.
- [12] Монгол Улсын Засгийн газрын 93-р тогтоол, УБ 2008 он.
- [13] Монгол Улсын Засгийн газрын 325-р тогтоол, УБ 2010 он.
- [14] Нийгмийн халамжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, УИХ, 2012 он
- [15] Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль /шинэчилсэн найруулга/, УИХ, 2016 он
- [16] Хүүхэд хамгааллын тухай хууль, УИХ, 2016 он.
- [17] Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, УИХ 2017 он.
- [18] Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль, УИХ 2005 он.
- [19] Ахмад настны тухай хууль /шинэчилсэн найруулга/, УИХ 2017 он.
- [20] Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, УИХ 2005 он
- [21] <http://rilsp.gov.mn/>
- [22] <http://www.habemt.gov.mn>
- [23] <http://hudulmur-halamj.gov.mn>
- [24] Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр. ЗГ, 2016 он.ХНХ сайдын А/26 тоот тушаал.
- [25] Хөдөлмөр эрхлэлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамж. 2017 он.
- [26] Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, УИХ 2004 он.

[27] <https://ikon.mn>

[28] <http://www.fcy.gov.mn/mn/index.php?pid=64&nid=276>

[29] Хэрэглэгчийн үнэлгээний тайлан 2017-2018 он. ГБХЗХГ, Эрүүл мэнд нийгмийн бодлогын хүрээлэн. УБ 2018 он.